



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-12</i>
<hr/>	
<i>1.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа</i>	<i>4-12</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Ж.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн;

Чөлөөтэй: Ж.Батжаргал, Г.Дамдинням;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд;

Тасалсан: Х.Ганхуяг.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн
ажиллагаа**

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нар оролцов.

Танхимын зүүн талд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, зөвлөх О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, мөн газрын дэд дарга С.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга А.Энхзул, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Пүрэвдагва, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Жамбалдорж, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Батманлай, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Парламентын судалгааны хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Парламентын номын сангийн дарга С.Янжинхорлоо, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга С.Зоригт, мөн албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан зөвлөх Л.Нинжжамц, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны дарга С.Эрдэнэболд;

Танхимын баруун талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа,

Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг;

Танхимын дээд лоожид Монгол Улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчид суудлаа эзэлсэн байв.

Танхимын баруун хойд болон зүүн хойд дэлгэцнээ “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлт. 2023.03.15” гэсэн үг гарч байв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогчид босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Нээлтийн ажиллагаа 10 цаг 22 минутад дуусав.

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн студи, Монгол кино нэгтгэлийн баримтат киноны зураглаачид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын Ерөнхий сайдын, Монгол Улсын Шадар сайдын, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн, “МОНЦАМЭ” агентлагийн, Зууны мэдээ, Өнөөдөр сонины, itoim.mn, Erennews.mn, Arslan.mn, Ergelt.mn, Zogii.mn, Eguur.mn, gogo.mn, mpa.mn сайтуудын гэрэл зурагчид сурвалжлав.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагааны бэлтгэл, зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийг сонсохоор 10 цаг 22 минутад хаалттай горимд шилжүүлэв.

Хуралдаан 2 цаг 06 минут үргэлжилж, 76 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 00 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданишатар: Улсын Их Хурлын гишүүдийн ирц 65.8-тай бүрдсэн байна.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын болон нийслэлийн удирдлагууд, мөн Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон олон улсын байгууллагын суурийн төлөөлөгчдийн газрын тэргүүн нар оролцож байна.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган нээхэд бэлэн болсон байна. Ингээд чуулганыг нээж үг хэлье.

Эрхэм хүндэт Ерөнхийлөгч,
Ерөнхий сайд аа,
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,
Хүндэт зочид оо,

Улсын Их Хурал цар тахлын аюул цаашилж, эдийн засаг тогтворжин, сэргэлт эхэлсэн урин дулаан цаг наашилсан энэ үед хаврын чуулганаа эхлүүлж байна.

2022 оны намрын чуулган 2 сар шахмын өмнө өндөрлөсөн ч Улсын Их Хурлын үйл ажиллагаа хуулийн хэлэлцүүлэг, нээлттэй сонсгол, Зөвлөлдөх санал асуулга, хурал зөвлөгөөн хэлбэрээр тасралтгүй үргэлжилж өрнөлөө. Гишүүд

маань тойрогтоо ажиллаж, иргэд сонгогчидтойгоо уулзан, санаа бодлыг нь сонслоо.

Иргэд олон түмний санал бодол, нийтлэг хүсэл эрмэлзэл, Зөвлөлдөх санал асуулгын үр дүн, Зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжид дурдсан асуудлууд, шинэ сэргэлт, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх 3 чиглэлээр 10 багц хуулийн асуудлыг хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөж байна.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлаас “Зөвлөлдөж шийдье” зөвлөлдөх санал асуулгын үйл ажиллагааг үндсэндээ 4 үе шаттай зохион байгуулж, улс орны нийгэм, эдийн засгийн өмнө тулгамдсан асуудлыг иргэдтэйгээ хамт тодорхойлсон.

Эхний шатанд “Нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал: Гарц шийдэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлаар эрдэмтэн судлаачид тулгамдсан асуудлуудаар илтгэл хэлэлцүүлж, гарц гаргалгаа шийдлийн талаар хэлэлцсэн.

Дараа нь улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагууд, жагсааж цугласан иргэдийн төлөөлөл оролцсон Үндэсний зөвшилцлийн чуулга уулзалтыг зохион байгуулж санал санаачилгуудыг хэлэлцсэн. Энэ бүхэн дээр үндэслээд ард иргэдийн оролцоог хангасан эдгээр уулзалтуудаас хамгийн олон давтамжтай гарсан асуудлуудаар 3, 4 дэх шатанд оролцогчдоос санал асуулгын 2 шаттай санал асуулгыг явуулсан.

Зөвлөлдөх санал асуулгын эхний шатанд Монгол орон даяар, социологийн шинжлэх ухааны санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 1570 иргэнээс санал асуулга авсан. 4 дэх шатанд буюу Төрийн ордонд болсон Зөвлөлдөх уулзалтад мөн санамсаргүй түүврийн аргаар нийт ард иргэдийг төлөөлж чадахуйц кластер нийгмийн бүлгүүдийг төлөөлж сонгогдсон 20-89 насны 801 иргэн эх орныхоо 4 зүг 8

зовхисоос хүрэлцэн ирж, сэдэв тус бүрээр тэнцвэртэй мэдээлэл авч, асууж ярилцаж, жижиг бүлгээр нарийвчлан хэлэлцэж зөвлөлдсөн. Ингээд зөвлөлдсөнийхөө үр дүнд тэд маань санал асуулгад хариулсан. Ард иргэд эрдэм шинжилгээний хуралд иргэний нийгмийн байгууллага, улс төрийн намуудаас гарсан асуудлуудыг зөвлөлдөх зөвлөл багцалж 4 багц сэдвийн хүрээнд боловсруулсан 22 асуулт тус бүрээр асууж тодруулсан.

Ингээд иргэд маань 22 асуулт тус бүрээр нарийвчлан зөвлөлдөөд хэлэлцээд саналаа өгсөн.

Санал асуулгад оролцогчид авлига хээл хахуультай тэмцэх асуудлыг бүх сэдвээр онцлон ярьж байсан бөгөөд төсөв мөнгө, төрийн өмчийн хяналтыг сайжруулахын тулд ард иргэдийг төлөөлөн ажилладаг төрийн хянан шалгах бие даасан тогтолцоо бүрдүүлэх асуудлыг өндөр хувиар дэмжсэн.

Ийм тогтолцоо нь төрд сахилга, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ тогтоож, авлигаас ангижрах чухал хөшүүрэг болох болно гэж дийлэнх олонх нь үзэл бодлоо илэрхийлсэн байна.

Санал асуулгын үр дүнгээр 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг амилуулах, хэрэгжүүлэх хуулиудыг яаралтай хэлэлцэн баталж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийнхөө үр дүнг үзэх шаардлагатай гэж үзсэн.

Жишээлбэл, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд туссан байгалийн баялгаас ард иргэд тэгш хүртэх, хүртээмжтэй байх, Үндэсний баялгийн сан байгуулах, Үндэсний баялгийн сангийн удирдлага нь мэргэжлийн, төрөөс хараат бус, олон нийтийн хяналтад ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй гэх асуудлыг оролцогчдын 90 хувиар буюу өндөр хувиар дэмжсэнийг Улсын Их Хурал, Засгийн

газар анхааралдаа авах ёстой. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг яаралтай өргөн барьж, хаврын чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг Засгийн газар, холбогдох сайд, гишүүд онцгойлон анхаарах хэрэгтэй байна.

Түүнчлэн парламентын иргэдийг төлөөлөх чадавхыг дээшлүүлэх, Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог мөнгөнөөс ангид, олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулан явуулах, улс төрийн намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалтыг ил тод болгохыг 80-аас дээш хувиар дэмжсэн байна. Мөн намын хатуу гишүүнчлэлээс татгалзах, төвлөрлийг сааруулахын тулд бүсчилсэн хөгжлийг эхлүүлэх, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг батлах, төрийн алба хаагчид хөрөнгө орлогоос гадна зарлагаа мэдүүлэхийг хуульчлах нь зүйтэй гэж иргэд үзсэн байна.

Хоёрдугаарт, Ард иргэдийн элч төлөөлөгч болсон гишүүд та бид тойрогтоо ажиллаж, иргэд сонгогчдынхоо санал бодлыг сонссон, уулзсан. Зөвлөлдөх санал асуулгаар ч гэсэн урьж, ингэж санал бодлыг нь сонслоо. Тэгэхээр энэ ард иргэдийн нийтлэг хүсэл эрмэлзэл санал бодол бол нийгмийн хорт хавдар болоод байгаа авлигын үндсийг таслахыг хүсч байна. Улсын орны хөгжил дэвшил, иргэдийн сайн сайхан амьдралын боломжийг үгүй хийж, хуулийн засаглал, төрт ёсыг үнэгүйдүүлж байгаа хорт үзэгдэл бол авлига юм гэж үзэж байна.

Иймээс энэ хаврын чуулган авлигын эсрэг эрх зүйн шинэчлэл хийсэн чуулган байх ёстой. Хаврын чуулганаар авлигатай тэмцэх чиглэлээр багц хуулиудыг хэлэлцэнэ. Энэ хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг багц хуулиудыг хэлэлцэж батална. Мөн

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн батална.

Хэдийгээр манай улс авлигын индексээр ухарсан үзүүлэлттэй байгаа ч шүүхээр шийдэгдсэн авлигын гэмт хэргийн тоо 2018 оныхоос 10 дахин өссөн байна.

Зөвхөн индекс хөөцөлдөх бус авлигын уг үндэс, шалтгаан нөхцөлтэй тэмцэх цогц бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ийм учраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг өргөн хүрээнд хэлэлцүүлнэ. Мөн саяхан Засгийн газраас авлигатай тэмцэх “Таван Ш” ажиллагааг эхлүүлснийг Улсын Их Хурал хуулийн бодлогоор дэмжиж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгаж хэлэлцүүлж ажил хэрэг болгож ажиллах шаардлагатай.

Ёс зүйг төлөвшүүлэх нь авлигагүй нийгмийн үндэс суурь юм. Ийм учраас Авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах шинэчлэлийн хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга харууллагын тухай хуулийг эхний хэлэлцүүлгийг явуулна, хэлэлцэх эсэхийг шийдсэн байгаа.

Нийгмийг эрүүлжүүлэхэд авлигыг үл тэвчих, нийтийн сайн сайхны төлөө хууль бус үйлдэл, авлигын гэмт хэргийг илчлэн мэдээлэгчийг хамгаалж, иргэдийн оролцоонд түшиглэдэг, иргэдийн оролцоотой энэ авлигатай тэмцэх үйл хэрэг чухал юм. Ийм учраас ийм хүсэл зориг, үзэл баримтлалаар Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Түүнчлэн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Авлига Монголын нийгэмд гүнзгийрснийг иргэд ярьж байна. Төрийн

байгууллага, албан тушаалтнуудыг тойрсон авлигын хэрэг байсхийгээд илэрч байна. Тэр битгий хэл иргэд эмнэлэгт үзүүлж, сургуульд хүүхдээ оруулахдаа хүртэл “Өгөх ёстой. Өгч байж сайн эмчлүүлнэ, хүүхдээ сайн сургана” гэсэн үзэл хандлагатай болсон байна гэж ярьж байна. Иймд Зөвлөлдөх санал асуулгад оролцогчдын олонх дэмжсэн төрийн хянан шалгах хараат бус, бие даасан тогтолцоо бүрдүүлэх асуудлыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Улс төрийн намын тухай хууль, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиас эхлээд Үндсэн хууль хүртэл авлигатай тэмцэх, авлигыг үл тэвчих үзэл санааг суулгаж өгөх хэрэгтэй гэж үзэж байна. Авлигатай тэмцэхэд төрийн бүх байгууллагуудын манлайлал, хүчин чармайлт чухал. Авлигыг үл тэвчих ард түмний нийтлэг хүсэл зориг нь цаг үеийн нөхцөл байдал, шаардлага, гарц шийдлийг илэрхийлдэг.

Парламентын ардчиллын үнэт зүйлийг тодруулахад тустай гэж үзсэн тул хууль тогтоох ажлын нэг бодит жишээг энд өгүүлье гэж бодож байна. Энэ бодит жишээ хуулийн түүх бол ард түмний хүсэл зоригийг зөв тусган авч, шинжлэх ухааны үндэстэй хэрэгжүүлбэл ямар бодит үр дүн гарч болох тухай юм.

2017 оны үндэсний хэмжээний анхдугаар Зөвлөлдөх санал асуулгын үеэр ард иргэдийн төлөөлөл олон хууль батлаад л байдаг, Улсын Их Хурал хууль үйлдвэрлэж батлаад л байдаг, харин хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын механизм байгуулах шаардлагатай гэсэн саналыг гаргасан. Энэ саналыг үндэслээд олон улсын туршилагыг судлаад шинжлэх ухааны үндэстэй судалж үзээд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн биелэлт, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурал хянан шалгах түр хороо байгуулж ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Тэр

үед бүр гэрч дуудах, мөрдөн шалгах ийм түр хороо байлгах шаардлагатай гэж хэлсэн.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг 2021 оны 12 дугаар сард баталж, 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Яг энэ хууль хэрэгжиж эхэлснээрээ парламентын хянан шалгах чиг үүргийг цоо шинэ шатанд гаргасан. Олон жил далд бугшсан хэр нь далд яригддаг байсан асуудлууд ил болж, Байнгын хороод, чуулганы хуралдаануудаар их бага шүгэл үлээгдэж, олон нийтийн анхаарлын төвд орсон. Тухайлбал, энэ хууль хэрэгжиж эхэлсэн 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Хөгжлийн банкны асуудлаар хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулагдсан. Улмаар 04 дүгээр сарын 03-ны өдөр Хянан шалгах түр хороо байгуулагдаж, ажиллаж эхэлсэн. Гэрч, холбогдогч тогтоох, шинжээч томилж нотлох баримт цуглуулах, шинжлэх аргаар олон жил ажилласан. Ингээд өнөөдөр энэ нээлттэй сонсгол нь үргэлжилж байна.

Хөгжлийн банкны, нүүрсний гэх мэт дуулиантай хэргүүдийн талаар чухамдаа Улсын Их Хурлын гишүүд л эхэлж шүгэл үлээж, олны анхааралд оруулсныг зориуд цохон тэмдэглэе.

Чуулганы завсарлагаагаар буюу энэ өнгөрсөн 1, 2 дугаар сард Хөгжлийн банкны Хянан шалгах түр хороо нотлох баримт шинжлэн судлах сонсголыг хоёр үе шаттай хийж, одоо гурав дахь шатны сонсгол явагдаж байна.

Энэ сонсголоор Хөгжлийн банкны нийт 7.8 их наяд төгрөгийн зээлийг хэн ямар зорилгоор авсан тухай мэдээллийг олон нийтэд ил тод болгосон. Ард иргэдийн мэдэх эрхийг хангасан.

Эхний 2 шатны сонсголоор Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн шууд

болон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй нийт 6.2 их наядын зээл, түүний ашиглалт, зарцуулалт, зээлдүүлэгч, зээлдэгчид, хамаарал бүхий этгээдүүдээс гэрчийн мэдүүлэг авах зорилгоор 432 зээлтэй холбоотой асуудлаар 365 иргэн, хуулийн этгээдийг гэрчээр дуудаж сонссон. Харин 3 дахь шатны сонсголоор Хөгжлийн банкны эх үүсвэрээр арилжааны банкнуудаар дамжуулан олгосон 2542 төсөл, хөтөлбөрийн 1.6 их наяд төгрөгийн зээлийн ашиглалт, зарцуулалтын талаар нийт 240 гаруй иргэн, хуулийн этгээдийг гэрчээр дуудан, оролцуулж байна.

Олны анхаарал татсан асуудлыг ил болгож, ард түмний мэдэх эрхийг хангах, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амь оруулж, Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж, шинэ жишиг тогтоож буй нийт гишүүддээ, энэ дотроо түр хорооны дарга, эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяраар ахлуулсан Түр хорооны гишүүдэд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс талархал илэрхийлье.

Энэхүү 3 шатны сонсголын эцэст Түр хорооны хуралдаанаас гаргах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж иргэдийн мэдэх эрхийг хангах, шүүхэд нотлох баримтыг хүргүүлэх нь нээлттэй сонсголын зорилго юм.

“Нүүрсний” хэргийн асуудлаар байгуулагдсан Түр хороо өнгөрсөн хугацаанд хил, гааль, тээврийн асуудлаар томоохон хяналт шалгалтыг явуулсан. Олон мянган хуудас нотлох баримтыг бүрдүүлж, шинжээч томилон ажиллуулж байна. Уг асуудлаарх нийтийн сонсгол зохион байгуулах саналыг ажлын хэсгийн ахлагч, эрхэм гишүүн Гочоогийн Ганболд болон ажлын хэсгийн гишүүд гаргасан байна. Та бүхэндээ амжилт хүсье.

Эрхэм гишүүд ээ,

Бид улсынхаа нийгэм, эдийн засаг, улс төрд эрх зүйн шинэчлэл хийх 10 багц хуулийг хэлэлцэн батлах зорилтыг дэвшүүлсэн. Тэдгээрээс авлигатай тэмцэх, улс төр, засаглалын чиглэлээр хийх шинэчлэлийн бодлогын үндсэн асуудлын талаар дурдлаа.

Бусад нийгмийн бодлогын хүрээнд 3 багц хуулийг хэлэлцэнэ. Боловсролын багц хуулийн хэлэлцүүлэг өндөрлөж, чуулганаар хэлэлцэхэд бэлэн болж байна. Боловсролоор дамжуулан хүнээ хөгжүүлж ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих, шударга, эв нэгдэлтэй нийгмийг төлөвшүүлэх, тогтвортой өсөлттэй эдийн засагтай болох боломж бүрдэнэ. Нийгмийн даатгалын багц хуулийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулах цогц бодлогын хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиа батлан гаргах, засаг захиргааны шинэчлэлийг нэг мөр хийх цаг болсныг Зөвлөлдөх санал асуулгын дүн нотолсныг тэмдэглэж хэлье. Энэ хуулиуд бэлэн болсон ч гэсэн жалга довын үзлээсээ салж чадахгүй байгаа нь нийслэлийн төвлөрөл, түгжрэлийг өөгшүүлж байна гэж үзэхээс өөр арга алга.

Гуравдугаарт, Сорилт, бэрхшээл цөөнгүй байгаа ч бүхэлдээ ирээдүй маань гэрэл гэгээтэй байна. Сүүлийн 3 жилийн гаруйн хугацаанд цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас үүдэлтэй хүндхэн сорилтуудыг Монгол Улсын эдийн засаг даван тууллаа. Харин одоо эдийн засаг сэргээж эхэллээ.

Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг 2022 оны хүлээлтээс харьцангуй өндөр буюу 4.8 хувийн өсөлттэй гарч, өсөлт энэ оны нэгдүгээр сарын урьдчилсан тооцооллоор 10.6 хувьд хүрлээ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт сэргэсэнээр оны эхний 2 сарын

байдлаар гадаад худалдааны тэнцэл 1.0 тэрбум ам.долларыг давсан. Үүний үр дүнд өмнөх оны нэгдүгээр сард 400 гаруй сая долларын алдагдалтай байсан урсгал дансны тэнцэл 50 сая долларын ашигтай гарлаа.

Нүүрс, алт, зэс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өсөж байна. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжид мэдэгдэхүйц ахиц гарч байна. Стратегийн ач холбогдол гэхэд төмөр замын бүтээн байгуулалтын ажил эрчимтэй өрнөж, Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэллээ.

Хэдийгээр эдийн засагт энэ мэт зэрэг үр дүн гарч байгаа боловч ард иргэдийн амьжиргаа, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж буй валютын хани, үнийн өсөлтийг нэн тэргүүнд хязгаарлах, гадаад өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлогын цогц арга хэмжээ авах нь Та бидний өмнө тулгамдсан хамгийн чухал шийдвэрлэх асуудлууд болоод байна. Тухайлбал, сүүлийн 18 сар дараалан хоёр оронтой тоонд хадгалагдаж, иргэдийн худалдан авах чадвар, бодит орлогод сөрөг нөлөө үзүүлж байгаа үнийн өсөлтийг хязгаарлах арга хэмжээг хугацаа алдагдалгүй авах шаардлагатай байна. Энэ хүрээнд Улсын Их Хурлын өнгөрсөн хаврын чуулганаар баталсан “Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтийг үнэлж, улмаар төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах замаар Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк хамтран инфляцыг бууруулах чиглэлд бодлогоо нэгтгэх шаардлагатай байна.

Аж үйлдвэр хөгжөөгүй, халамж, хэрэглээнд суурилсан эдийн засгийн бүтэцтэй, уул уурхайн цөөн

бүтээгдэхүүнд экспорт маань тулгуурладаг, импортоос хэт хараат эмзэг байдал цаашид удаан үргэлжилж болохгүй.

Тиймээс эдийн засгаа төрөлжүүлэх, үйлдвэржилтийг сэргээх шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай байна. Хувийн хэвшлийг дэмжих хэрэгтэй байна. Үйлдвэрлэлээ дэмжин хөгжүүлэх хэрэгтэй байна. Бизнес эрхлэгчдийг дэмжиж, экспортлогч улс орон болох нь одоогийн нэн тэргүүний зорилт юм.

Экспортын цогц бодлого, хөтөлбөр баталж, төрөөс татвар, зээлийн бодлогоор тусгайлан дэмжих бодлого хэрэгтэй байна. Ингэж байж төлбөрийн тэнцэлд гарсан эерэг өөрчлөлтөө бататгана.

Бид эдийн засагтаа гарсан өнөөдрийн хүндрэлийг даван туулахаас гадна Монгол Улсын эдийн засаг, хөрөнгө оруулалт, бизнесийн орчны суурь өрсөлдөх чадварыг сайжруулах эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд энэ хаврын чуулган анхаарах ёстой.

Төр нь хувийн хэвшилтэй өрсөлддөг биш дэмждэг, хориглодог биш зохицуулдаг болох ёстой. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх чиглэлээр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиудыг хэлэлцэн батлах ажил хүлээгдэж байна. Эдийн засаг дах төрийн оролцоог хязгаарлах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг хэлэлцэн батлахаар хүлээгдэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаа дуусахад жил гаруйхан хугацаа үлдэж байна. Улс орны улс төрийн болон цаг үеийн нөхцөл байдал

бидэнд багагүй сорилт бэрхшээл үүсгэж ч мэднэ.

Дэлхий дахины болон улс орны геополитикийн нөхцөл байдал, гадаад дотоод эрх ашгийн огтлолцлыг сайтар тооцож, Монгол хэмээх улс орныхоо үндэстний язгуур эрх ашгийг бид эн тэргүүнд бодож ажиллах ёстой. Гагцхүү хуульд захирагдаж, эв нэгдэл, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа эрхэмлэх нь зүйд нийцнэ. Аливаа шийдвэрийг Монгол төр, Монгол Улсын ирээдүйн эрхэм зорилгод нийцүүлэн, олон талаас нь нухацтай тунгаан бодож гаргах нь төр түшигж буй бидний эрхэм үүрэг мөн.

Монгол Улсад эдийн засгийн, улс төрийн, нийгмийн тогтвортой байдал ус агаар мэт чухал байна. Тогтвортой байдал бол хөгжил цэцэглэлтийн суурь нөхцөл, аюулгүй байдлын цөм юм. Тогтворгүй байдал бий болгох сонирхол дотроос ч, гаднаас ч харагддаг. Үүнээс сэргийлэх, улс үндэсний эрх ашгаа дээдлэх нь нэн чухал. Түүнчлэн цар тахал, дайнаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн хямралыг дагасан боломжуудыг бид бүрэн ашиглах ёстой. Хямралыг боломж болгон үсрэнгүй хөгжих боломж бидэнд байна. Үүний тулд дотоод ойлголцол, эв нэгдлээ эрхэмлэх шаардлагатай.

Амжилт ололт, сургамж ухаарал, сорилт шийдэл хосолсон ийм цаг үед илүү ухаалаг, илүү зөв, илүү үр бүтээлтэй ажиллахыг цаг үе биднээс шаардаж байна. Ингэж ажиллаж чадна гэдэгт Та бүхэндээ итгэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.

/Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэв/

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы ажиллагаа үүгээр өндөрлөж байна.

Одоо нэгдсэн хуралдаанаар Монголын Улсын Ерөнхийлөгч, Төрийн тэргүүн Ухнаагийн Хүрэлсүх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хаалттай мэдээллийг сонсоно.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн хүндэт зочдодоо баярлалаа.

Эрхэм Элчин сайд нарт талархал илэрхийлье.

Зочид, төлөөлөгчдөдөө баярлалаа.

Одоо нэгдсэн хуралдаанаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хаалттай мэдээллийг сонсоно.

Нэгдсэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлье.

Г.Занданишатар: Нэгдсэн хуралдааныг нээлттэй горимд шилжүүлье.

Одоо нэгдсэн хуралдаан завсарлаад Байнгын хороод хуралдана. Төрийн байгуулалтын байнгын хороо “Жанжсин Д.Сүхбаатар”-ын танхимд 12 цагт хуралдана. Зөвлөлдөх санал асуулгын үр дүнгийн талаар Зөвлөлдөх зөвлөлийн мэдээлэл сонсоно.

Байнгын хорооныхоо энэ сард хэлэлцэх цаглавар, ажлын төлөвлөгөөг батлах ёстой.

Хууль зүйн байнгын хороо Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

Ингээд ер нь Байнгын хороод бүгд өнөө, маргааш хуралдаж тухайн сард хэлэлцэх асуудлын тов, цаглавар батлах ёстой. Тэгж байж дараагийн асуудлуудаа, энэ хугацаатай, хориг товоос бусад бүх асуудлуудыг бол цаглавар баталсны үндсэн дээр хэлэлцэж эхэлдэг учраас өнөө, маргаашидаа цаглавраа батална.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА